



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 263051, Факс: (976) 7004-3479,
E-mail: info@energy.gov.mn

2022. 01.10 № а/98
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ц.НЯМДОРЖ ТАНАА

Иргэд аж ахуйн нэгжүүдээс 2021 оны жилийн эцсийн байдлаар Эрчим хүчний яамны албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдлын талаарх тайланг хавсралтаар гарган хүргүүлж байгааг хүлээн авна уу.



Н.ТАВИНБЭХ

170600040



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Сайдын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд:

Иргэд, аж ахуйн нэгжээс 2021 оны жилийн эцсийн байдлаар Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайланг Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Г.Бадамцэцэг танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.Өргөдөл, гомдлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газарт даалгав.

2.Иргэд, аж ахуйн нэгжээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг чиг үүргийн дагуу хүлээж авсан албан тушаалтан эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариуг өгөх, салбарын үйлдвэр, компаниудад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг яамны газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгов.” гэжээ.



Н.ТАВИНБЭХ

170600093

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Тус яам нь иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол Улсын хууль, бусад хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүдээс 2021 оны жилийн эцсийн байдлаар яамны хэмжээнд ирүүлсэн өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээ, танилцуулгыг тогтоосон журмын дагуу хугацаанд нь гаргаж, удирдлагуудад танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яаманд 2021 оны жилийн эцэст нийт 287 өргөдөл, гомдол ирснээс 281 өргөдлийг шийдвэрлэсэн, үүнээс хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй, бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн өргөдөл, гомдол - 35 байна. Шийдвэрлэлтийн хуулийн хугацаа болоогүй */хяналтад/* 6 өргөдөл, гомдол байгаа бөгөөд нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн биелэлт 97.9% байна.

Тайлант хугацаанд хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тайланг хавсралт 1, 2, 3-аар тус тус гарган хүргүүлж байна.

---ooOoo---



Иргэд, аж ахуйн нэгжүүдээс яам болон сайд, төрийн нарийн бичгийн даргад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээ

/2021 оны жилийн эцсийн байдлаар /

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт | Үүнээс: | | | | |
|---|------------------|--|---------|-----------------|----------------|-----------------|-------|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| 1 | Эрчим хүчний яам | 287 | 278 | 6 | - | 3 | - |

Тайлбар: 11-11 төвөөс шилжүүлж ирүүлсэн өргөдөл, гомдлыг тайланд оруулаагүй болно.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

---ooOoo---

а/98 тоот албан бичгийн
хоёрдугаар хавсралт

Иргэд, аж ахуйн нэгжээс яам болон сайд, төрийн нарийн бичгийн
даргад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

/2021 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэлт |
|---|------------------|--------------------------------|------------------------|--|--|-----------------------------|-------------|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн | Хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй /хяналтад/ | |
| 1 | Эрчим хүчний яам | 287 | 281 | 35 | - | 6 | 97.9% |

---ooOoo---

2/198 тоот албан бичгийн
гуравдугаар хавсралт



Өргөдөл, гомдлын төрөл, агуулга

| д/д | Байгууллагын нэр | Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь/ |
|-----|------------------|--|
| 1 | Эрчим хүчний яам | <p>Нийт 287 өргөдлөөс: Хүсэлт – 244 / 85 % Гомдол – 42 / 14.6% Санал – 1 / 0.3%</p> <ol style="list-style-type: none">1. Ажилд орох, гарах, чөлөө хүсэх, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, зэрэг төрийн болон салбарын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл баталгаа, тусламж дэмжлэгтэй холбоотой асуудлаар – 123 / 42.8%2. Удирдлагын үйл ажиллагаа, Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 61 / 21.5 %3. Түлш эрчим хүчний үйлдвэрлэлтэй холбоотой асуудлаар - 58 / 20.2 %4. Тусгай зөвшөөрөл, тендер, техникийн нөхцөлтэй холбоотой асуудлаар - 19 / 6.6 %5. Бусад асуудлаар - 26 / 9 % |

---ooOoo---